



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 152

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1,6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон нийт 20,629,522,935.00 (хорин тэрбум зургаан зуун хорин есөн сая таван зуун хорин хоёр мянга есөн зуун гучин таван) төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг хавсралтад заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газарт эзэмшүүлж үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Иргэний нисэхийн ерөнхий газрын газрын дарга Л.Бямбасүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



132001378

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 
дугаар тогтоолын хавсралт

Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн
жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ (ам.доллар)	Хөрөнгийн үнэ (ам.доллар)
1	Ачаа, шуудан тээврийн үйлчилгээний барилга	ш	1	8,071,750,997.00	8,071,750,997.0
2	Захиргааны барилга	ш	1	4,071,761,446.00	4,071,761,446.0
3	Нисэх буудлын үйлчилгээний барилга	ш	1	8,486,010,492.00	8,486,010,492.0
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3 (гурав)				20,629,522,935.00 (хорин тэрбум зургаан зуун хорин есөн сая таван зуун хорин хоёр мянга есөн зуун гучин таван)